



УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБА-нд

УЛААНБААТАР ХОТЫН БАНК
УЛААНБААТАР САЛБАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж, Бага тойруу -15,
Утас: 31-21-55, 320527, Факс: (976-11) 31-21-55,
И-мэйл: info@ubcbank.mn

2019.01.24 № 06-11/017

танай _____-ны № _____-т

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГАА

“СҮХБААТАР ДЭВШИЛ ОНӨААТҮГ” (цаашид “гүйцэтгэгч” гэх) нь УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА (цаашид “захиалагч” гэх)-тай зарласан ЗЦ-01/19-06 дугаартай “Санзай сэлх чиглэлийн алдагдсан замын цэвэрлэгээ” ажлын гэрээ (цаашид “гэрээ” гэх) хийх болсонтой ХОЛБОГДУУЛАН.

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй баталгааг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 15160, Их Эзэн Чингис хааны нэрэмжит талбай 11 хаягт орших Улаанбаатар хотын банк (цаашид “банк” гэх) нь дараах баталгааг гаргаж байна.

Банк гүйцэтгэгчийн нэрийн 9,279,375 төгрөг /Есөн сая хоёр зуун далан есөн мянга гурван зуун далан таван төгрөг/-өөс хэгрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА -ын өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зорчсон тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурьдсан 9,279,375 төгрөг /Есөн сая хоёр зуун далан есөн мянга гурван зуун далан таван төгрөг /-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнгийн талаар ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардах эрхтэй.

Захиалагч, гүйцэтгэгч хоёрын хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтанд оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гарснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстой.

Энэхүү баталгаа нь зөвхөн эх хувиараа хүчинтэй бөгөөд аливаа нэгэн хуулбар нь хуулийн хүчин төгөлдөр бус байна.

Баталгааны хүчинтэй байх хугацаа дууссан эсвэл баталгааны эх хувь банкинд буцаан хүргэгдсэн тохиолдолд уг гүйцэтгэлийн баталгаа нь хүчингүй болно.

Та бүхнийг хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



И. ОЮУНГЭРЭЛ